



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 4/143

Эрдэнэт


Зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан Барилга захиалагчийн дүрмийн 3.2.3 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын барилга захиалагчийн хяналтын зардлын талаархи 2015 оны 1/1065 дугаар зөвлөмжийн дагуу, барилгын материалын чанарт хяналт тавих лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хэвийн үйл ажиллагааг явуулах, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын яамны захиалгат барилга угсралт, их засварын ажилд чанар аюулгүй байдлыг хангах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх ажиллагааг явуулахад зарцуулах 29346135/Хорин есөн сая гурван зуун дөчин зургаан мянга нэг зуун гучин таван / төгрөгийн зардлыг хавсралтын дагуу баталсугай.

2.Энэхүү зардлыг барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 2016 оны гэрээний үнийн дүнгээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /н.Цолмон/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
03 дугаар сарын 23-ны өдрийн
1143 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Зардлын дүн
1	Цалингийн зардал	17997416
2	Ажил олгогчоос НДШ	1979716
3	Шатахуун, сэлбэг хэрэгсэл	1400000
4	Сургалт зөвлөгөөн	3000000
5	Архивын нэгж болгон хадгалах зардал	535193
6	Барилгын чанар аюулгүй байдлын талаар нийтэд ил тод мэдээлэх сургалт, сурталчилгааны зардал	1500000
7	Захиалагчийн хяналт хэрэгжүүлэхэд хийгдэх геодези хэмжилтийн байнгын ажиллагаатай станцын түрээс интернетийн төлбөр	2933810
	Нийт дүн	29346135